

## **БОЛОВСРУУЛААГҮЙ НООС, НООЛУУРЫН АГУУЛАХАД ТАВИГДАХ ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

(Үйлдвэрийн боловсруулалт хийгдээгүй ямааны ноолуур,  
хонины ноос, тэмээний ноос, бодын хөөврийг хадгалах агуулах)

### **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

- 1.1. Агуулахын эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 1.1.1. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
  - 1.1.2. Агуулахын эзэн (өмчлөгч), эсвэл агуулахыг түрээслэн ажилладаг байх;
  - 1.1.3. Хугацаа хэтэрсэн (татвар, банкны болон бусад) өргүй байх;
  - 1.1.4. Ноос, ноолуурын чиглэлээр тогтвортой ажиллаж мэргэшсэн барааны мэргэжилтэнтэй байна.
- 1.2. Агуулах нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 1.2.1. Орон нутагт болон Улаанбаатар хотын Автозамын шалган нэвтрүүлэх товчоодоос гадагш байрлалтай;
  - 1.2.2. Монгол улсын MNS 5364:2011 стандартын шаардлагыг хангасан;
  - 1.2.3. Багтаамж нь тухайн орон нутагт агуулахын зориулалтаар үйл ажиллагаа явуулахад тохиромжтой;
  - 1.2.4. Тасралтгүй ажиллах боломж, нөхцлийг хангасан дэд бүтэцтэй;
  - 1.2.5. Агуулахын хашаа нь биржийн барааг саадгүй ачих, буулгах боломжтой, тээврийн хэрэгсэл зогсох, хөдлөх хангалттай талбайтай;
  - 1.2.6. Мал эмнэлэг, ариун цэврийн газрын ариутгал, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу тогтмол хийлгэдэг;
  - 1.2.7. Агуулах, түүний хашаа нь 24 цагийн харуул хамгаалалттай, камержуулсан;
  - 1.2.8. Цагийн хуваарь мөрдөж ажилладаг;
  - 1.2.9. Биржийн хүлээн зөвшөөрсөн дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:
    - Стандартчилал хэмжилзүйн газраас баталгаажуулсан гэрчилгээ бүхий баталгаат жин, пүү;
    - Шаардлагатай тохиолдолд пресслэгч (шахуургын) төхөөрөмж;
    - Шаардлагатай тохиолдолд хөргөлт, халаалтын систем;
    - Шаардлагатай тохиолдолд өргөх, буулгах, ачих төхөөрөмж;
  - 1.2.10. Биржийн агуулахын бүртгэлийн програмыг саадгүй ажиллуулах боломжтой компьютер, принтер, 1mb-аас доошгүй хурдтай интернэт, 4mb нягтралтай IP камер зэрэг дагалдах тоног төхөөрөмжтэй байх

1.2.11. Барааны бүртгэл хөтлөх ажилтантай байна.

### **ХОЁР. БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

2.1. Итгэмжлэл хүсэгч нь дараах баримт бичгийг Биржид бүрдүүлж өгнө. Үүнд:

- 2.1.1 Итгэмжлэл хүссэн өргөдөл;
- 2.1.2. Агуулахын албан ёсны болон орон нутгийн хаяг, байршил, байнга харилцах утас, имэйл;
- 2.1.3. Агуулахын үндсэн ажилчдын товч анкет;
- 2.1.4. Агуулахын тоног төхөөрөмжийн талаарх бүрэн мэдээлэл;
- 2.1.5. Агуулахын хашааны урт, өргөн болон хашаан доторх агуулах тус бүрийн чанар, багтаамжийн мэдээлэл;
- 2.1.6. Агуулах тус бүрийн гаднах, доторх зургууд (8х12-оос доошгүй хэмжээтэй, булан, хана, шал, тааз, хаалга, тоног төхөөрөмжийг дэлгэрэнгүй харуулсан);
- 2.1.7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүний хуулбар;
- 2.1.8. Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түүний хуулбар;
- 2.1.9. Хэрэв агуулахыг түрээслэдэг бол түрээсийн гэрээ, түүний хуулбар;
- 2.1.10. Татварын байгууллагын тодорхойлолт, түүний хуулбар;
- 2.1.11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, түүний хуулбар;
- 2.1.12. Агуулахын тоног төхөөрөмжийн гэрчилгээ, түүний хуулбар;
- 2.1.13. Мал эмнэлэг, ариун цэврийн газрын халдваргүйжүүлэлтийн гэрээ, түүний хуулбар.
- 2.1.14 Итгэмжлэлийн гэрчилгээний нэг удаагийн хураамж болох 300,000 (гурван зуун мянган) төгрөгийг
  - Хаан банк 5131004545
  - Төрийн банк 106000999991 эдгээрийн аль нэг дансанд тушаасан баримт

2.2. Бүрдүүлэх баримт бичгийн 2.1.1-2.1.6 заалт дахь баримтыг албан бичгээр үйлдэж, тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байна.

2.3. Бүрдүүлэх баримт бичгийн 2.1.7-2.1.13 заалт дахь баримтыг эх хувиар нь авчрах боломжгүй бол нотариатаар тухайн онд баталгаажсан хуулбарыг авчирч болно.

### **ГУРАВ. ИТГЭМЖЛЭЛ СУНГАХАД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ**

3.1. Итгэмжлэлийн гэрээний хугацаа дуусахаас ажлын 10 өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах гэрээ сунгуулах хүсэлтийг Биржид гаргана.

3.2. Итгэмжлэл сунгуулахад бүрдүүлэх баримт бичиг:

- 3.2.1. Итгэмжлэл сунгуулах өргөдөл, албан бичгээр;
- 3.2.2. Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1.2-2.1.6 заалтад бүрдүүлсэн баримт бичгүүдээс өөрчлөгдсөн баримт бичиг;

3.2.3. Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1.7-2.1.13 заалт дахь баримт бичгүүдээс (хугацаа дууссан болон бусад шалтгаанаар) шинэчлэгдсэн баримт бичиг.

3.3. Итгэмжлэл сунгахад шаардагдах баримт бичгийг хүлээн авахдаа энэ шалгуур үзүүлэлтийн 2.2 болон 2.3-т заасан нөхцлийг баримтална.

—oOo—